

*Г.Золбоо -Хууль сахиулахын их сургууль, Хууль сахиулах
удирдлагын академийн 8032 дугаар
дамжааны суралцагч, цагдаагийн хошууч*

*Б.Одбаатар -ХСИС-ийн Хууль сахиулахт
удирдлагын академийн Цагдаагийн удирдлага,
стратегийн профессорын багийн профессор,
хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн хурандаа*

**ГЭМТХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА,
НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХБАЙГУУЛЛАГААС АНХААРЧ
ШИЙДВЭРЛЭВЭЛ ЗОХИХ ЗАРИМ А СУУДАЛ**

Хураангуй: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэж гэмт хэргийн гаралтыг бууруулах, түүнийг төрүүлдэг шалтгаан нөхцөлийг аажмаар арилгахад чиглэгдсэн төр, олон нийтийн байгууллага, иргэдээс зохион байгуулж байгаа үйл ажиллагааны цогц юм.¹

Түлхүүр үгс: Цагдаагийн байгууллага, гэмт хэрэг, нутгийн өөрөө удирдах байгууллага, урьдчилан сэргийлэх,

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг судалж, хариу авах арга хэмжээний шийдвэр гарган хэрэгжүүлэх, уйл ажиллагааны үр дүнг үзэх ажил байдаг. Хөндөж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил улсын хэмжээнд болон тодорхой бүс нутагт ямар байх уу гэдгийг төр засгийн болон орон нутгийн түвшинд томъёолж гаргаж ирэх ёстой. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамгийн түрүүнд юу хийх ёстойг тодорхойлох асуудал юм.

Хуульд зааснаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний цар хүрээнээс хамааруулан ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн гэж ангилсан.

Гэмт хэргээс урьдчилан тухай хуулийн 3 дугаар зүйлд 3.1-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн”^{1 2} заалтыг хэрэгжүүлж ажиллах явдал туйлын чухлаар тавигдаж байна. “Гэмт хэрэгтэй тэмцэх” нь урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах, шүүн таслах, гэмт этгээдэд ял эдлүүлэх цогц ажиллагаагаар тодорхойлогдох ёстой байтал өнөөдөр илрүүлэх,

¹ Н.Жанцан “Криминологи” УБ хот, 2004 он, 86-р тал

² Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль УБ хот, 1997 он

таслан зогсоох ажилд түлхүү анхаарч, урьдчилан сэргийлэх ажил хавсарга байдалтай байна.

Гэмт хэргээс урьдчилан ажлыг үр дүнтэй зохион байгуулахын тулд зохион байгуулах хүнээ чадвартай байх, чадваржуулах, дэмжих нь маш чухал. Ажилтнуудынхаа асуудалд онцгой анхаарч, боловсон хүчнийг шилж сонгож авах, тэдний ёс суртахуун, мэргэжил боловсрол, ур чадварыг байнга дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарахгүй бол авилгал, хээл хахуулийн асуудлаас хол байх, бусдын нөлөөнд автахгүй, биеэ даасан үйл ажиллагаа явуулах нь учир дутагдалтай.

Үүнийг шийдвэрлэх нь аймаг, дүүргийн салбэр зөвлөлийн эдийн засгийн боломж, нөхцөл бололцоо, боловсон хүчний дутагдалтай байдал, ажлын ачаалал гэх мэт янз бүрийн шалтгаантай холбогддог ч хууль хяналтын байгууллагынхан шийдвэрлэх арга замуудыг дор бүрнээ эрэлхийлж, асуудлыг бодлогын түвшинд авч үзэж, шинэчлэлт өөрчлөлтийг хийж байх ёстой.

Төр засгаас гэмт хэрэг тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалж иргэдийн амгалан тайван амьдрах, олгогдсон эрх, эрх чөлөөг эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд ажлын үндэс, эхлэл нь урьдчилан сэргийлэх ажил сайн байх ёстой.

Улс орны болон тухайн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын чиг хандлагад бодитой дүн шинжилгээ хийж, түүний дагуу гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах бодлогоо оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх хэрэгтэй.

Жишээ нь: Аймаг, дүүрэг, баг, хорооны нутгийн өөрөө удирдах болон төр захиргааны байгууллагаас төлөвлөсөн ажил бүрэн биелэж, тэр бүр оновчтой байх албагүй ч Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан гэмт хэрэг, зөрчлийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж шалтгаан нөхцөлийг тодорхойлсон, үнэлэлт дүгнэлт өгсөн холбогдох байгууллага, ялангуяа цагдаагийн байгууллагаас ирүүлсэн танилцуулга, мэдээлэл, тайлан, санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа ашиглаж, урьдчилан сэргийлэх ажлын иш үндэс болгох нь зүйтэй.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд урьдчилан сэргийлэх ажил, хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээг хуучин явж ирсэн практик, ажлын туршлага дээр үндэслэн ерөнхий таамгаар ажлаа төлөвлөж, зохион байгуулдаг. Энэ арга барилыг өөрчилж тодорхой бодитой судалгаанд үндэслэн ажлаа төлөвлөх, зохион байгуулах шаардлага ч тавигдаж байна.

Ингэснээр тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг үүдэн гарч буй шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, үр дүнтэй

урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажилд ахиц гарна гэж үзэж байна.¹

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрт иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, амар тайван, аюулгүй орчинг бий болгох, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг хамруулах зэрэг ажлуудын хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран ажилладаг. Энэ чиг үүргийн хүрээнд хийгдэх ажлын нэг хэсэг нь урьдчилан сэргийлэх ажил байдаг.

Хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд цагдаагийн албаны хууль шинэчлэгдэн батлагдаж Цагдаагийн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд нилээдгүй өөрчлөлт гарсан ба үүнтэй уялдан цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бие даасан нэгжтэй болсноор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд олон нийтэд түшиглсэн хэлбэрээр явуулах болсон. Үүнтэй уялдан нутгийн удирдлагаас хууль сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд цагдаагийн байгууллага болон иргэдтэй хамтран ажиллаж байгаа асуудлыг судлах шаардлага бий болсон.

“Сайн хуульч гэмт хэрэг үйлдсэний төлөө шийтгэхийн оронд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар анхаарал тавина”^{1 2} хэмээсэн нь аливаа гэмт хэргийг үйлдэгдэхээс өмнө урьдчилан сэргийлэхэд цаг хугацаа, хүн хүч, хөдөлмөр, зардал хэмнэсэн төр, олон нийт, ард иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд нийцсэн чухал ач холбогдолтой байдаг.

Монгол улс 1997 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуультай болсон. Энэ хуулиар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл, арга хэлбэр, энэ ажилд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж өгсөн билээ.

Энэ хуулийг бүх түвшинд хэрэгжүүлэх асуудалд онцгой анхаарч, нутгийн өөрөө удирдах болон төр захиргаа, хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар санал, санаачлага гарган урьд ажиллаж ирснээсээ илүү ажиллах хэрэгтэй байгаа юм.

¹ “Гэмт явдалтай тэмцэх арга зүй” УБ хот, 2011 он

² Ш.Монтескы Избранные произведения Москва. 1955 г, 231-р тал

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шатанд ч хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог бий болгон хуульчлах шаардлага байхыг үгүйсгэхгүй юм. Өөрөөр хэлбэл үр дүн нь учирч болох хохирол, эсрдлээс аврагдана.

‘Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн’ гэж хуульчилсан нь гэмт хэрэг үйлдэгдэн гарч буй шалтгаан нөхцөлийг зөв тогтоож, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хэргийн гаралтыг саармагжуулах, тогтворжуулах улмаар бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээ юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь шалтгаан нөхцөл бүрт нөлөөлж чадахаар, байнга, тасралтгүй, иж бүрнээр зохион байгуулагдах ёстой.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь шинжлэх ухаанд тулгуурласан, хуульд нийцсэн, бодитой, үндэслэлтэй, ашиг хэрэгцээтэй, дайчин давшингүй, байнгын байх нь үр дүнд хүрэх нэг алхам болно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дараахь үндсэн чиглэлээр зохион байгуулж хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гэмт хэргийн талаархи мэдээллийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох;
- Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
- Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоох;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүй татан оролцуулах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах;

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил дор дүрдсэн төрөлтэй байна’.

Үүнд:

- Ерөнхий арга хэмжээ;
- Тусгай арга хэмжээ;
- Нэг бүрчилсэн арга хэмжээ

¹ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйл

² Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйл

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх *ерөнхий арга хэмжээ* гэнэ.

Тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх *тусгай арга хэмжээ* гэнэ.

Тодорхой этгээд гэмт хэрэг үйлдэхээс болон давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх *нэг бурчилсан арга хэмжээ* гэнэ.

Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах асуудал онолын түвшинд баяжиж, улам боловсронгуй болж байгаа хэдий ч практикт нэвтрүүлэх, үр дүнг ашиглах явдал төдийлөн хангалттай бус байгаа байдал ажиглагдаж байгаа юм.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дор дурдсан үүргийг гүйцэтгэнэ:¹

а/гэмт хэргийн статистикийн мэдээ, цахим зураглал, холбогдох бусад мэдээлэлд үндэслэн хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүгнэлт хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах;

б/хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар мэдэгдэл бичих, түүний биелэлтэд хяналт тавих;

в/нутгийн захиргааны байгууллагаас томилсон нийтийн болон хэв журмын урамшилтай эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтны үйл ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах;

г/нутгийн захиргааны байгууллага, төрийн байгууллага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

д/хорих ял эдэлж суллагдсан, хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллагдсан болон тэнсэгдсэн ялтанд хяналт тавих.

¹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” код
227

Цагдаагийн байгууллага үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дээрх үндсэн чиглэл, төрлөөр зохион байгуулахдаа дараах байдлаар ажиллах хэрэгтэй.

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн, төрийн бус байгууллага, албан газар, аж ахуйн нэгж, иргэдийн хүч туслалцааг авч, тэдэнтэй хамтран ажиллах.

2. Цагдаагийн байгууллагын ажилд иргэд, олон нийтэд сурталчлахын зэрэгцээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох мэдээллийг иргэд, байгууллагад цаг алдалгүй шуурхай хүргэх,

3. Цагдаагийн байгууллага, алба хаагч өөрийн ажлаа нутаг дэвсгэрийн иргэд, олон нийтэд жилд хоёроос доошгүй удаа тайлагнан, гарсан санад шүүмжлэлийн мөрөөр ажил зохиох,

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар биечлэн радио телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилгаа явуулах,

5. Нутгийн захиргаа болон төрийн бус байгууллагаас зохиож байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хамтран ажиллах,

6. Олон нийтийн байцаагч, нийтийн болон урамшилт эргүүл, жижүүрт үүргээ хэрхэн биелүүлэх талаар зөвлөгөө өгөх, тэдэнтэй хамтран ажиллах зэргээр мэргэжлийн удирдлагаа хангах,

7. Нийгэм, тухайн нутаг дэвсгэрт гарч буй гэмт хэрэг, зөрчил болон учирч буй бэрхшээлтэй асуудлуудыг тогтоон түүнд нөлөөлж буй шалтгаан, нөхцөлийг судлан дүн шинжилгээ хийх,

8. Шалтгаан, нөхцөлийг арилгах хариу арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэх,

9. Хариу арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийх,

10. Шаардлагатай бол нэмэлт арга хэмжээ авах зэргээр ажиллана.

Мөн цагдаагийн ажил үйлчилгээг иргэд, олон нийтэд харагдахаар нээлттэй, холбоо барих боломжтойгоор явуулах, иргэдтэй харилцан түншлэлийн харилцаа тогтоохыг эрхэмлэх, иргэд, төрийн бус байгууллагын яриа, санал, зөвлөмж, шаардлагыг тухай бүр хүлээн авч, холбогдох хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагаас анхаарч шийдвэрлэвэл зохих зарим асуудал:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, түүний харьяа байгууллагуудыг нийтлэг үүргийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж, бүх нийтийн үйл хэрэг болгож ажиллах;

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, түүнд сум, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарыг татан оролцуулах, тэдний гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиг үүргийн хэрэгжилтийг улирал тутам тооцож сургалт-мэдээлэлд хамруулдаг байх;

3. Урьд нь ял шийтгэгдсэн, хорихоос суллагдсан,ял тэнсэн харгалзсан иргэдийг засрал хүмүүжлээ олоход нь туслах, ажлын байраар хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулах;

4. Тодорхой эрхэлсэн ажилгүй иргэдийг ажлын байраар хангах, ялангуяа гэмт хэргийг голлон 18-30 насны ажилгүй залуучууд үйлдэж байгаад дүгнэлт хийж, тэднийг аж ахуйн нэгж, байгууллага, компанид ажилд зуучлан тэдний дэмжлэгтэйгээр хамтран шийдвэрлэх, урамшууллын механизм хэрэглэх;

5. Харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсийн криминологи судалгааны багийн үйл ажиллагааг дэмжиж, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын судалгаанд үндэслэсэн урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах, хөрөнгө, санхүүгийн туслалцаа дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

6. Байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн хүч, дэмжлэгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд авч ажиллах;

7. Иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны талаар сурталчлах, соён гэгээрүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмолжуулах;

8. Нийслэл хот, төв суурин газарт шинээр баригдах барилга байгууламж, орон сууцны хорооллын зураг төслийг батлах шалгуур үзүүлэлтэд дохиолол, гадна, дотны орчинг хянах телекамерийн хяналтын системтэй байх нөхцөлийг тусган хэрэгжүүлэх;

9. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, алба хаагчийн ажиллах нөхцөл, ахуй хангамжийг сайжруулахад анхаарч нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх;

10. Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх оновчтой хувилбар бүхий үйл ажиллагааны орчинг бүрдүүлж ажиллах;

11. Гудамж, талбай, нийтийн зах, аж ахуйн нэгж, байгууллагын орчин, орон сууц, гэр хорооллыг байнгын гэрэлтүүлэгтэй болгох, теле камерын хяналтад авах ажлыг оршин суугчид, Сууц өмчлөгчдийн холбоодтой хамтран шийдвэрлэх;

12. Оюутан, сурагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг таниулах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон